ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг.Товч танилцуулга:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2-т Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга, эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэхээр заасан.

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-д заасны дагуу 7 гишүүнтэйгээр Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 74 дүгээр захирамжаар байгуулсан бөгөөд дэд хороог Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга ахлан ажиллаж байна.

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо 2025 онд төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой 24 гомдол, мэдээлэл хүлээн авсан. Ёс зүйн гомдол, мэдээллийг ангилбал:

- Яамны удирдах болон гүйцэтгэх албан хаагчтай холбоотой гомдол, мэдээлэл 21 хувийг;
- Засгийн газрын агентлагийн удирдах албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээлэл 21 хувийг;
- Төрийн бусад байгууллагын удирдах албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээлэл 17 хувийг;
- Аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга болон улс төрийн албан хаагчтай холбоотой гомдол, мэдээлэл 29 хувийг;
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээлэл 12 хувийг тус тус эзэлж байна.

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо 2025 онд нийт 5 удаа хуралдаж 7 гомдол, мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу хянан шалгаж, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Үүнээс:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн удирдах албан тушаалтан болон сумын Засаг даргын ёс зүйн асуудалтай холбоотой гомдол, мэдээллийг хянаж шалгах үйл явц, хуралдааныг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, дүгнэлтийн төслийг боловсруулан Ёс зүйн дэд хорооны гишүүд, даргад хянуулж, гомдол гаргагч, гомдол хамаарагчид хууль тогтоомжийн дагуу хүргүүлсэн.
- Бусад гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлж, зарим байгууллагын Ёс зүйн дэд

хороонд холбогдох зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх арга хэмжээг авч ажилласан.

Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д төрийн албан хаагч үйл ажиллагаандаа сахин мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тусгаж, мөн хуулийн 7.3-т төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5-д заасан этгээд *(төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан)*-ийн ёс зүйн хэм хэмжээг Засгийн газар тогтоохоор заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5-д заасан этгээдийн дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээний төслийг боловсруулан Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлуулсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академиас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсанаас хойш буюу 2023 онд танхимаар 3233, 2024 онд танхимаар 554, цахимаар 36830, 2025 онд танхимаар 454, цахимаар 1092 албан хаагчийг “Ёс зүйт манлайлал, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага”, “Ёс зүйн менежмент”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвийн хүрээнд холбогдох сургалтад хамруулаад байна.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтанд зориулсан ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар заасан байдаг.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар болон Засгийн газрын агентлагийн дарга нарт “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга сургалтад оролцогчдод хандан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг сахин биелүүлэхэд онцгойлон анхаарах, өөрийн эрхлэх асуудлын хүрээний төрийн болон төсвийн холбогдох байгууллагуудыг мэдээлэл, зөвлөмжөөр хангаж Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах чиглэлийг өгсөн.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар “Ёс зүйн дэд хорооны хуралдааны дэг” болон “Ёс зүйн дэд хорооны 2024-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэлэлцэн баталж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.3-т заасан дэд хорооны бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо 2024 онд 20, 2025 онд 24 төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шалгах, зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэх, эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын Ёс зүйн дэд хороодод гомдол, мэдээлэлтэй холбоотой зөвлөмж, мэдээллийг хүргүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт 11 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 1500 гаруй албан хаагчид хамрагдсан бөгөөд яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Агентлагийн дарга, бүх аймгийн сумын Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрдэнэс Монгол нэгдэл, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын удирдах болон эрх бүхий албан тушаалтнаас гадна Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Зам, тээврийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалтын газар, Барилгын хөгжлийн төв зэрэг байгууллагын албан хаагчид хамрагдсан.

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2 албан хаагчийг Монгол Улсын Ёс зүйн дэд хороо болон Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан “Ёс зүйн сургагч багш бэлтгэх” хөтөлбөрийн дагуу 4 хоногийн танхимын сургалтад хамруулав.

Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс хийж гүйцэтгэсэн “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ”-ний ажилд Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, ирсэн гомдол, мэдээлэл, тэдгээрийг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал, ёс зүйн зөрчлийн кейс, жишээ болон олон улсын туршлагын талаар танилцуулга, мэдээлэл бэлтгэн өгч судлаачдын багтай хамтран ажилласан.

Гурав.Гарсан үр дүн, ололт амжилт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академиас төрийн албан хаагчдад зориулж “Ёс зүйт манлайлал, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага”, “Ёс зүйн менежмент”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтуудыг танхимаар болон цахимаар тогтмол явуулж байна.

Мөн Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтнууд болон төрийн захиргааны зарим байгууллагын албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн

тухай хуулийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Дээрх ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтын үйл ажиллагааны үр дүнд албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэг, мэдээлэл сайжирч байна.

Дөрөв.Бэрхшээл, санал

Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаарх саналыг доорх байдлаар тодорхойллоо. Үүнд:

1/Хуулийн 7, 8 дугаар зүйлд төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлага, хориглох зүйлтэй холбоотой асуудлыг нэгтгэн зохицуулсан боловч нэр томьёоны тодорхойлолт оновчгүй, нийтлэг хэм хэмжээ, шаардлага, хориглох зүйлийг тодорхой зааглаагүйгээс ёс зүйн зөрчилд ямар үйлдэл, эс үйлдлийг тооцох нь ойлгомжгүй, төрийн албан хаагчийн гаргасан бүх төрлийн зөрчил ёс зүйн зөрчилд хамаарах мэт ойлголтыг төрүүлж байна.

Хуулийн энэхүү хийдэлтэй байдал нь Ёс зүйн дэд хороодод ирүүлэх гомдол, мэдээллийн тоог өсгөхөөс гадна шийдвэр, түүний үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Иймд хуульд “ёс зүй, ёс суртахуун, ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн шаардлага, хориглох зүйл” зэрэг нэр томьёо, тодорхойлолтыг ойлгомжтой болгож, ёс зүйн зөрчлийг зөв тодорхойлох шалгуур, үндэслэлийг нарийвчлан хуульчлах шаардлагатай байна.

2/Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг тогтооход хуулийн 8.1, 8.2 дахь хэсгийг баримтлахаар заасан боловч тус зохицуулалт нь Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг ишлэн заасан нь хууль хооронд давхардал үүсгэж байна. Өөрөөр хэлбэл, Ёс зүйн дэд хороод нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс гадна сахилгын болон авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргийг бүхэлд нь хамруулан шалган шийдвэрлэх мэт ойлгомжгүй байдал, зөрчлийг үүсгэж байна.

3/Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын дагуу Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй, “Ажлын алба”-гүйгээр ажиллаж байна.

Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 14.3.2-т зааснаар аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга нар, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтны ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэх үүрэгтэй.

Тодруулбал, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо хамгийн багадаа 4000 орчим албан хаагч (дүүргийн Засаг дарга 9, сумын Засаг дарга 330, хорооны Засаг дарга 152, багийн Засаг дарга 1568, яамдын Төрийн нарийн бичгийн дарга 16, Засгийн газрын агентлагийн дарга 36, Засгийн газраас томилдог бусад албан

тушаалтан 20, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан 1500 орчим)-ийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэхээр байна. Мөн эдгээрээс гадна улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч, төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн зөрчлийн асуудлыг ч давхар хариуцан ажиллана.

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 7 гишүүн үндсэн чиг үүргийн зэрэгцээ хуульд заасан албан хаагчдын ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэж байгаа нь ажлын ачаалал, цаг хугацааны хувьд тус чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэхээс гадна хуульд заасны дагуу газар дээр нь нэмэлт шалгалт хийх боломж, нөхцөл хязгаарлагдмал байна.

Иймд Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд Засгийн газраас томилогддог албан тушаалтны ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг, харин аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга болон Авлигын эсрэг хуулийн 4.1.3-т заасан этгээд (төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан)-тэй холбоотой ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг **харьяалах дээд шатны байгууллагын** Ёс зүйн дэд хороо буюу томилох эрх бүхий байгууллага нь хариуцан шалгаж, шийдвэрлэхээр хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

4/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10.2-т Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн асуудлыг хариуцах, мөн хуулийн 13.3-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан боловч гомдол, мэдээлэл шалгаж, шийдвэрлэх хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга буюу улс төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлыг хариуцахаар зөрүүтэй байдлаар зохицуулсан байна.

Тодруулбал, улс төрийн албан тушаалтны ёс зүйн асуудлыг төрийн захиргааны албан хаагчдаас бүрдсэн Ёс зүйн дэд хороо хянан, шийдвэрлэх болсон нь Төрийн албаны тухай хуулийн зарчимтай зөрчилдөж байна.

Иймд сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга буюу улс төрийн албан тушаалтны ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх асуудлыг тухайн албан тушаалтныг томилох эрх бүхий албан тушаалтан хариуцан хэрэгжүүлэхээр хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

5/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15.6-д ёс зүйн зөрчилтэй холбоотой дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдол, мэдээлэл гаргасан этгээд түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харьяалах дээд шатны байгууллагын Ёс зүйн хороонд гомдол гаргахаар заасан боловч Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 10 дугаар тогтоолоор дээрх гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх Ёс зүйн дэд хороодыг тогтоосон нь хуулиас давсан шийдвэр болохоос гадна бодит байдалд хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.

Иймд Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг эс зөвшөөрсөн гомдлыг хянан, шийдвэрлэх бүтэц, түүний харьяалал, чиг үүрэг зэргийг хуульд нарийвчлан зохицуулах нь зүйтэй байна. Тухайлбал, энэ төрлийн гомдлыг Монгол Улсын Ёс

зүй хороо, эсхүл орон тооны бус гишүүдээс бүрдсэн бие даасан Ажлын алба (хэсэг) хянан шийдвэрлэхээр хуульд өөрчлөлт оруулах саналтай байна.

6/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15.6-д Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг эс зөвшөөрсөн гомдлыг зөвхөн гомдол, мэдээлэл гаргасан этгээд харьяалах дээд шатны байгууллагын Ёс зүйн дэд хороо, эсхүл Ёс зүйн хороонд гаргахаар хязгаарлан заажээ.

Өөрөөр хэлбэл, маргалдаж байгаа хоёр талын зөвхөн нэг тал нь Ёс зүйн хороонд гомдол гаргах боломжтой бол нөгөө тал буюу ёс зүйн зөрчилд холбогдогч нь Ёс зүйн хорооны дүгнэлтэд гомдол гаргах эрхгүй. Харин тус дүгнэлтийг үндэслэн гаргасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэртэй холбогдуулан шүүхэд гомдол гаргахаар байна.

Ийнхүү гомдол гаргагч болон ёс зүйн зөрчилд холбогдсон этгээдийн гаргасан өргөдлийг шалган шийдвэрлэх үе шатыг хуульд харилцан адилгүй тогтоосон нь хувьд "Хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх" Үндсэн хуулийн зарчмыг үндэслэлгүйгээр хязгаарласан зохицуулалт болжээ.

Иймд зөрчилд холбогдсон төрийн албан хаагч Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг эс зөвшөөрч гомдол гаргах, мөн ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд оногдуулсан шийтгэлтэй холбогдуулан гомдол гаргагчийн шүүхэд хандах эрхийг хязгаарлаж байгаа хууль зүйн үндэслэлийг тодорхой болгож, хуульчлах шаардлагатай байна.

7/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд Ёс зүйн дэд хорооны гишүүний ёс зүйтэй холбоотой асуудлыг хянан шийдвэрлэх эрх бүхий субъектыг тодорхой заагаагүй бөгөөд тус чиглэлээр хэм хэмжээний акт батлан мөрдүүлэх эрх хэмжээг Ёс зүйн хороонд хуулиар олгоогүй байтал тогтоол батлан мөрдүүлж байгаа нь хуульд нийцэхгүй байна.

Иймд Ёс зүйн дэд хорооны гишүүний ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх эрх бүхий субъектийг тодорхой болгох асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай байна.

8/Хуулийн 7.2-т төрийн улс төрийн, төрийн тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжоор тогтооно гэж заасан.

Гэвч төрийн улс төрийн албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон болон тодорхойлох эрх олгосон зохицуулалт бүхий хууль тогтоомж байхгүй байна.

Иймд төрийн улс төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоох эрх бүхий албан тушаалтан, эсхүл байгууллагыг тодорхой хуульчлан тогтоох шаардлагатай байна.

Олон улсын туршлагаас үзэхэд төрийн албан хаагч ажил, үүргээ үнэнчээр биелүүлж, эрх мэдлээ хувьдаа ашиглахгүй байхыг “ёс зүй” гэж үзэж, төрийн албаны зарчим, үнэт зүйлст харш үйлдэл гаргахгүй байхад анхаардаг.

Гэтэл манай улсын өнөөгийн хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний харилцаа, хандлагатай холбоотой зөрчлийг хянан шалгах, шийдвэрлэх зохицуулалт давамгайлж байгаагаас төрийн албан хаагчид өөр хоорондын маргаан, үйл ойлголцлын асуудлаар Ёс зүйн дэд хороонд гомдол гаргаж, түүнийг шалган тогтооход хүндрэлтэйн улмаас бусдын нэр хүндэд халдах, хууль бус аргаар нотлох баримт цуглуулах гэх мэт зөрчил, гомдол ихсэх хандлагатай байна.

Түүнчлэн Үндэсний аудитын газраас 2024 онд хийсэн “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар төрийн байгууллагын ёс зүйн асуудлаар гарсан дараах дүгнэлт, зөвлөмжид анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэж байна.

1. “Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороодын гишүүдийн урамшуулалд улсын төсвөөс жилд 47.6 тэрбум төгрөг, 5 жилд 238.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар байгаа боловч энэ хэмжээний зардал гаргаад төрийн албан хаагчийн ёс зүй дээшлэх эсэх нь тодорхойгүй байна. Иймд төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх үр дүнтэй ажлыг өөр арга замаар зохион байгуулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.”;

2. “Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлыг шалгаж, шийдвэрлэх хамрах хүрээ харилцан адилгүй байгаа нь ёс зүйн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа харилцан адилгүй байх, хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх сөрөг үр дагавартай байхаар харагдаж байна.”;

3. “Ёс зүйн асуудал нэрээр төрийн албан хаагчид бусдынхаа нэр төрд халдах сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй байх тул Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хүчингүй болгох эсвэл өөр зохион байгуулалтын арга хэмжээ авах нь зүйтэй байна.”;

4. Аудитын тайлангийн “Зөвлөмж”-ийн “Улсын Их Хурлын анхааралд” хэсэгт “Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд тодорхой урамшууллыг улирал тутамд олгохоор заасан нь улсын төсөвт жил бүр 47.6 тэрбум, 5 жилд 238.1 тэрбум төгрөгийн ачаалал үүсгэхээр байх тул ёс зүйн харилцааг зохицуулах өөр үр дүнтэй арга замыг сонгон хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.”

ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО